


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-48 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 12 аймагт **2118** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 2118 тохиолдлын 96% /2024/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 4% /94/ нь орон нутагт (Баян-Өлгий /34/, Дорнод /4/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Дархан /4/, Говь-Алтай /3/, Баянхонгор /1/, Дундговь /1/, Хэнтий /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **651** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **48** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.11.23 – 11.29)

2025 оны эпидемиологийн 48 дугаар долоо хоногт 56 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 46.2 хувиар буурсан бол 5 жилийн дунджаас 0.72 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-48 дугаар долоо хоногт** нийт **1295** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


740Эмнэлгийн
тусламж авч буцсан**555**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
47%Эмэгтэй
53%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 48 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **30** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 114 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 173 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 48 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	0	2	2
2	Эмийн хордлого	10	18	28
Нийт		10	20	30

Нийт 30 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 28 (93.3%) нь эмийн хордлого, 2 (0.07%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 20 (66.7%) тохиолдол, санаатай хордлого 10 (33.3%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-oOo-